


ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын мэдээллийн хуудас 2019 оны 6 сарын дугаар

Тэргүүн мэдээ

Монголд анхны Их сургуулийн эмнэлэг болох “Монгол-Японы сургалтын эмнэлэг” барилга байгууламж бэлэн болсоныг онцлох ёслолын үйл ажиллагаа зохион байгуулагдлаа.



6 сарын 16-ны өдөр буцалтгүй тусламжийн хамтын ажиллагааны хүрээнд баригдсан Монгол-Японы сургалтын эмнэлэг –ийн барилга байгууламж бэлэн болсоныг онцлох ёслолын үйл ажиллагаа зохион байгуулагдлаа. Ерөнхий сайд У.Хүрэлсүх, Япон улсын гадаад хэргийн сайд Коно болон хоёр орны төр засгийн төлөөлөл уг арга хэмжээнд оролцсон ба Ерөнхий сайд У.Хүрэлсүх нь Монголын анхны их сургуулийн эмнэлэг болохын хувьд эмнэлгийн чадвартай боловсон хүчнийг бэлтгэн гаргах үйлсэд их хувь нэмэр оруулна гэж найдаж буйгаа илэрхийлсэн юм. Цаашид эмнэлгийн үйл ажиллагааг эхлүүлэхэд ТХА-ны хүрээнд “Монгол-Япон Сургалтын Эмнэлгийн хүний нөөцийг чадавхижуулах, менежментийг төгөлдөршүүлэх төсөл”-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх юм.

Төслийн хэрэгжилт

(ТХА) Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төслийн үр дүнг танилцуулсан семинар болов



5 сарын 28-ны өдөр ТХА-ны “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төслийн” үр дүнг танилцуулах семинар болж, 150 гаруй хүн оролцов. Семинараар 2019 оны 7 сард өндөрлөх уг төслийн хүрээнд бий болгосон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрт илрүүлэлт, оношлогоо, хөгжлийн дэмжлэгийн загвар болон хөгжлийн үнэлгээний хэрэгсэл зэрэг төслийн үр дүнг танилцуулав. Эдгээрийн дотроос ХНХЯ, БСШУСЯ, ЭМЯ “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх зааврыг” баталсан нь хамгийн том үр дүн болж байна. Тухайн өдрийн семинарын тухай телевизийн мэдээгээр гарсан бөгөөд бичлэгийг ЖАЙКА-ийн Монгол дахь төлөөлөгчийн газрын [Youtube](#) -д байршуулсан тул үзэж сонирхоорой.

ХААИС-ийн Мал эмнэлгийн сургуулийн хичээлийн хөтөлбөрийг сайжруулахаар ажиллаж байна.



6 сарын 12-ны өдөр ТХА-ны “Мал эмнэлэг, МАА-н салбарын хүний нөөцийн хөгжлийн чадавхийг бэхжүүлэх” төслийн хамтран зохицуулах хорооны 7 дугаар хурал хуралдаж ХААИС-ийн захирал болон холбогдох бусад хүмүүс оролцлоо. Төсөл 2019 оны 4 сард хэрэгжиж дуусах байсан ч 2020 оны 5 сар хүртэл сунгагдан МЭС-н хичээлийн хөтөлбөр, хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулахаар ажиллаж байна. Хурал дээр төслийн үлдсэн хугацаанд хийгдэх үйл ажиллагаа, хэрэгжилтийн хуваарийг холбогдох талууд ярилцаж, цаашид сургалтын чанарыг тогтмол сайжруулж явах тогтолцоог бий болгох тал дээр анхаарч ажиллахаар боллоо.

Зээлжих зэрэглэл тогтоох байгууллагын (CRA) тухай семинар зохион байгуулав.



6 сарын 13-ны өдөр ТХА-ны “Монгол улсын хөрөнгийн зах зээлийн чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийн 2-р шатны үйл ажиллагааны хүрээнд Япон болон Бангладешийн ээлжих зэрэглэл тогтоох байгууллагын төлөөлөл Сангийн Яам болон Санхүүгийн Зохицуулах Хороо зэрэг холбогдох байгууллагуудад зориулж, хөрөнгийн зах зээл дэхь хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн зэрэглэл тогтоох хууль эрхзүйн орчин, зэрэглэл тогтоох байгууллага (CRA) байгуулахын ач холбогдол, олон улс дахь жишээг танилцууллаа. Мөн хөрөнгийн зах зээлд оролцогч байгууллагууд (арилжааны банк ба даатгалын компани зэрэг) –д зориулан Монгол шиг зээлийн мэдээлэл хангалттай хуримтлагдаагүй хөрөнгийн зах зээлд зээлжих зэрэглэл тогтоох байгууллагын гүйцэтгэх үүрэг, үнэлгээ хийх аргачлалын талаар бодит жишээн дээр тайлбарлав. Оролцогчдын зүгээс гарсан асуултуудад хариулж, чөлөөтэй санал бодлоо солилцсон үр дүнтэй семинар боллоо.

Улаанбаатар хотын агаарын бохирдлын хяналтын чадавхыг бэхжүүлэх төслийн 3-р үе шатны хамтарсан зохицуулах хорооны 2-р хуралдаан болов



6 сарын 7 –ны өдөр ТХА-ны “Улаанбаатар хотын агаарын бохирдлын хяналтын чадавхыг бэхжүүлэх төслийн 3-р үе шатны” хамтарсан зохицуулах хорооны 2-р хуралдаан болов. Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газар, БОАЖЯ зэрэг холбогдох байгуулгууд оролцож, төсөл эхэлснээс хойш хагас жилд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны явц, цаашдын төлөвлөгөөг танилцуулснаас гадна харьцангуй хэрэгжих боломжтой агаарын бохирдлын хяналтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх, холбогдох байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэхээр болсон байна. Цаашид туршилтын төслөөр сайжруулсан түлш үйлдвэрлэн, үр нөлөөг нь хэмжиж, автомашины хаягдал хийг бууруулахад чиглэсэн дохиоллын удирдлагыг туршихаар төлөвлөж байна.

Бусад төслийн үйл ажиллагаа.

- 6 сарын 14-ний өдөр: Урт хугацааны мэргэжилтэн Фужий Минору ((ТХА) Барилгын салбарын хөдөлмөрийн аюулгүй байдлын менежментийн чадавхийг бэхжүүлэх төслийн) буцав.
- 6 сарын 30-ны өдөр: Урт хугацааны мэргэжилтэн Оокума Хироши((ТХА) Анхан ба хоёр дахь шатлалын төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төсөл) ирэв.

ЖАЙКА-ийн сайн дурын гишүүдийн үйл ажиллагаа

Эрүүл мэнд, нийгмийн халамжийн салбарын сайн дурын гишүүдийн санал солилцох уулзалт



6 сарын 6-ны өдөр эрүүл мэнд, нийгмийн халамжийн салбарт үйл ажиллагаа явуулж буй сайн дурын гишүүдийн үүсгэн байгуулсан “Солонго” зөвлөлийн санал солилцох уулзалт болж, холбогдох сайн дурын гишүүд болон тэдний харьяа байгууллагуудын эрүүл мэндийн ажилтан нийт 24 хүн оролцлоо. Энэ удаагийн уулзалтаар “Хоол хүнс” сэдвээр ярилцаж, шим тэжээл бүхий эрүүл хүнс, амны хөндийн эрүүл ахуйг сахих арга, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хооллоход нь дэмжлэг үзүүлэх тухай, эмнэлгийн хоол болон өвчтнийг асарч буй гэр бүлийнхэнд нь зориулсан энгийн хоол, эрүү нүүрний дасгал зэрэг олон агуулгаар санал солилцож, аргачлалуудыг танилцуулав.

Оролцогчдын зүгээс уулзалт дээр яригдсан зүйлийг тус тусын байгууллагадаа туршиж үзэх, энэ чиглэлээр семинар зохион байгуулах сонирхолтой байгаагаа илэрхийлж байсан бөгөөд ижил мэргэжлийн хүмүүс харилцан мэдээлэл солилцох боломж бүхий чухал арга хэмжээ болж өндөрлөлөө.

Сайн дурын бусад үйл ажиллагаа.

- 6 сарын 24-ний өдөр: 2017 оны 2-р ээлжийн дараах сайн дурын гишүүн томилолтын хугацаагаа амжилттай дуусгаад нутаг буцлаа. Фүкүшима Мики (Мэргэжил: Байгалийн ухааны багш/ Харьяа байгууллага: Дундговь аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар)



Футаки багшийн “Монгол ба японы замнал” лекц болов.



6 сарын 5-ны өдөр ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газар, Японд төгсөгчдийн JDS нийгэмлэг болон ЖАЙКА-ийн сургалт төгсөгчдийн холбоо хамтран Токиогийн Гадаад хэлний их сургуулийн хүндэт профессор Хироши Футакийн “Монгол ба японы замнал” сэдэвт лекцийг зохион байгууллаа. Лекцийн хүрээнд 1911 оны тусгаар тогтнол зарлах үеийн монгол орны байдал, номонхааны хэрэг явдал, япон, монголын харилцааны одоогийн байдал ба ирээдүй гэх мэтчилэн япон, монголын шинэ ба нэн шинэ үеийн түүхийг тодорхой танилцуулсан юм. Энэхүү лекц нь Японд төгсөгчдийн JDS нийгэмлэг болон ЖАЙКА-ийн сургалт төгсөгчдийн холбооны гишүүдэд хоёр орны харилцааны талаар дахин эрэгцүүлэн бодох таатай боломжийг олгов.

Бие даасан захиргааны хуулийн этгээд Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага.(ЖАЙКА)
Монгол дахь төлөөлөгчийн газар.
Бодь цамхаг, 7 давхар, Сүхбаатарын талбай 3, Улаанбаатар, Монгол улс
(Төв шуудан, шуудангийн хайрцаг: 682, Улаанбаатар 15160, Монгол улс)
Утас:+976-325939, 311329, Факс:+976-310845 /E-mail: mg_oso_rep@jica.go.jp
Web: www.jica.go.jp/mongolia/index.html/FB: [JICA Mongolia](https://www.facebook.com/JICA.Mongolia)